



EURASIA CAPITAL
HOLDING JSC

“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 он 01-р сарын 04 өдөр

Дугаар: 22/02/01

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ
НЭМЭГДҮҮЛЭХ, НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 31, 42 дугаар зүйлүүд, 2022 оны 01-р сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь нээлттэй хувьцаат компанийн хувьд үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа явуулахад Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журамд заасан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах шаардлагатай байгаа тул хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг таван тэрбум төгрөг хүртлэх хэмжээгээр нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхдээ олон нийтэд, хаалттай хүрээнд болон стратегийн хөрөнгө оруулагчдад нэр заан эзэмшүүлэхээр таван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гарган уг шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
3. Хувьцаа нэмж гаргахтай холбоотой үнэ тогтоох, холбогдох төлөвлөгөө, дүгнэлтүүдийг батлах, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХАЛИУНАА





“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 он 01-р сарын 04 өдөр

Дугаар: 22/02/02

Улаанбаатар хот

ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2022 оны 01-р сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гаргах шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Компанийн үйл ажиллагааны чиглэлд Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг нэмж Санхүүгийн Зохицуулах Хорооноос холбогдох тусгай зөвшөөрлийг авч компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
3. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаатай холбогдох дүрэм, журам батлах эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
5. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХАЛИУНАА



“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 01 сарын 04 өдөр

Дугаар: *22/02/03* Улаанбаатар хот

ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 53, 54-р зүйлүүд, 2022 оны 01-р сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрэмд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан 2022 оны 01-р сарын 04 өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцоогүй, оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй.
2. Нэмж хувьцаа гаргах зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрсний дараа шаардах эрхийн хүрээнд нэгж хувьцааг худалдаж авах үнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоосон үнээр эргүүлэн худалдан авахыг зөвшөөрсүгэй.
3. Компанид хувьцаагаа эргүүлэн худалдахаар хүсэлт захиалгаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах үүргийг Компанийн тухай хуулийн 53-р зүйлийн 53.3-т заасны дагуу хяналтын багцын хувьцаа эзэмшигчдэд зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХАЛИУНАА



“ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 01 сарын 04 өдөр

Дугаар *22/02/04* Улаанбаатар хот

ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУВЬЦАА ЭЗЭМШҮҮЛЭХ
ЭРХ ЭДЛҮҮЛЭХ ЭСЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62.1.8, 38 дугаар зүйлүүд, 2022 оны 01-р сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таван тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргахтай холбоотойгоор одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХАЛИУНАА